



ТӨРИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН
ЭТГЭЭДИЙН ЗАХИРАЛ, ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ НАРТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

13381 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Энхтайвны өргөн чөлөө 16, Засгийн газрын IX байр,
Утас/Факс: (976-51) 26 23 50, И-мэйл: info@pcsp.gov.mn,
Вэбсайт: www.pcsp.gov.mn

2022. 06. 13 № A-1/1235
танай -ны № -т

Чиглэл хүргүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр “Иргэд олон нийттэй харилцах 11-11 төвийн үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 187 дугаар тогтоол гарсан.

Уг тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд иргэдээс амаар, бичгээр, цахим сүлжээ болон радио, телевизийн шууд нэвтрүүлгээр, түүнчлэн тусгайллан ажиллуулсан утсаар ирүүлсэн өргөдөл, гомдлыг бүртгэн авч, судалж шийдвэрлэн хариу өгч, шийдвэрийн хэрэгжилтийг шалгах, шийдвэрлэлтийн явцыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлэх, хууль тогтоомжоор тогтоосон өөрийн байгууллагын эрхлэх асуудлын хүрээг нийтэд зарлан сурталчлах зэрэг ажлыг зохион байгуулан, өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн үйл ажиллагааг сайжруулан ажиллахыг чиглэл болгож байна.

Иргэд, олон нийтээс танай байгууллагад болон дээд шатны төрийн захиргааны байгууллагаас уламжлуулан ирүүлсэн өргөдөл, гомдлыг хууль тогтоомжид заасан хугацаанд багтаан шийдвэрлэж, шийдвэрлэлтэд хяналт тавьж, мэдээллийг нэгтгэн дүн шинжилгээ хийж, санал, дүгнэлтийг нийтэд мэдээлж, тайланг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт улирал тутам ирүүлж ажиллахыг мэдэгдье.

Хавсралт /.. хуудастай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Т.Уранжидэр
Дуга-ж
Аяхаадж
албанчлал
Б.Мөнгөн
132008907
2022.06.22
A-4/2022